



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А1484

Номгон

Г “МБГЦ” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт  
шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“МБГЦ” ХХК-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт, баримт бичгийн бүрдэлд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Хишигбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Сарангарав Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга  
Э.Ганзориг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Ц.Болорчимэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Геологи, уул уурхайн хяналтын Улсын байцаагч  
Т.Мөнхжаргал Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч  
Б.Наранбаатар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн  
Т.Ариунзаяа Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Газарзүй мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн  
Ц.Доржнамжин Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн  
Б.Гантулга Гурванбулаг сумын Засаг дарга  
Д.Болд-Аюуш Гурванбулаг сумын Буга III багийн Засаг дарга  
Ш.Нархүү Гурванбулаг сумын Байгаль орчны хяналтын Улсны байцаагч  
П.Түвшинтөгс Гурванбулаг сумын Буга III багийн малчин (Зөвшилцсөнөөр)  
Б.Сумъяабилгүүн Гурванбулаг сумын Буга III багийн малчин (Зөвшилцсөнөөр)

642311251


Нарийн бичгийн дарга:

Б.Намуун

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхай хариуцсан бодлогын мэргэжилтэн

2.Хяналт шалгалтын ажлыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж дүгнэлтийг гарган танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН